



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

### Дотоод аудитын газрын ажлыг дүгнэх, төлөвлөгөөг батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.23 дахь заалт, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дотоод аудитын газрын 2023 оны ажлыг “Хангалттай” үнэлгээтэйгээр дүгнэсүгэй.
2. Дотоод аудитын газрын 2024 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. 2024 оны ажлын төлөвлөгөөг биелүүлж ажиллахыг Дотоод аудитын газар (Ч.Цоодол)-т үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга (Э.Түвшинчулуун)-д даалгасугай.


ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



Э.ТҮВШИНЧУЛУУН


П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн  
118 дугаар тогтоолын хавсралт



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажлууд	Хийгдэх хугацаа	Хүрэх үр дүн
1	Хорооны даргын 2023 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх;	2-3 дугаар саруудад	2023 оны 01 тоот тушаалын биелэлтийг дүгнэн холбогдох зөвлөмж гаргасан байна.
2	Хорооны холбогдох нийт ажилтнуудад зохицуулалтын үйл ажиллагааны эрсдэлийг эрт илрүүлэх, түүнийг бууруулах, хэрхэн зайлсхийх талаарх холбогдох сургалтыг зохион байгуулах, ДАГ-аас нэгжүүдийн хийсэн эрсдэлийн үнэлгээг нэгтгэн дүгнэхдээ арга зүй болон хэрэгжүүлэлтийн байдалд хяналт тавьж ажиллах;	3 дугаар сард	Хорооны үйл ажиллагааны эрсдэлийн түвшин 4-өөс 6 функтаар буурсан байна.
3	Хорооны холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны авлига, ашиг сонирхлын эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ хийх ажлыг Хорооны ЭБАТ-тай хамтран хийж зөвлөмжөөр хангаж ажиллах;	4 дүгээр сард	Үнэлгээ хийгдэж зөвлөмж гарсан байна.
4	АНЗЗ-ийн үйл ажиллагаанд өгсөн зөвлөмжийн биелэлтийн байдалд гүйцэтгэлийн аудит хийх; (Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Булган, Архангай, Хөвсгөл)	5-6 дугаар саруудад	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
5	Хорооны архив, албан хэрэг хөтлөлтийн байдалд аудит хийх;	8 дугаар сард	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
6	Дулааны нэг худалдан авагчтай загварын үйл ажиллагаанд аудит хийх;	9-10 дугаар сард	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
7	Сэргээгдэх эрчим хүчний компаниудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг дүгнэсэн байдалд аудит хийх;	10-11 дүгээр сард	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
8	Холбогдох байгууллагаас Хороонд өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд болон Үндэсний аудитын газар (ҮАГ)-ын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;	Жилдээ	Зөвлөмжийн биелэлтийг хангах чиглэлд ажлууд хийгдсэн байна.
9	Хорооны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу тусгайлан явуулах бусад аудит, судалгаа хийх;	Жилдээ	Тухайн чиглэлээр аудит хийгдэж холбогдох дүгнэлт, зөвлөмж гарсан байна.